



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/33

Баянхутаг сум

**МАЛ АМЬТНЫ СЭГ ЗЭМ УСТГАЛ,
ОРЧНЫ ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалтууд, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/181 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Мал амьтны сэг зэмээс хүн малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2025 оны 04 дугаар сарын 01-нээс 2025 оны 05 дугаар сарын 01 – ийг хүртэл хугацаанд Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгжүүд, Байгаль хамгаалагч, Багийн засаг дарга нар хамтран зохион байгуулсугай.

Сэг зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг “Сац манал” ХХК-ийн малын эмч /Н.Санжаадамба/, “Унаган туур” БГБХН-ийн захирал /Ж.Гэрэлмаа/, “Буман сувд гэрэл” ХХК-ний малын эмч /Х.Сувд-эрдэнэ/, “Чандмань талын тан” ХХК-ний малын эмч /Ч.Зоригтчулуун/ нарт үүрэг болгосугай.

Мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ариутгалын бодис, халдвар хамгаалалтын хувцас хэрэгслээр хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, Сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн ажлын дүн мэдээг, холбогдох байгууллагад танилцуулахыг мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч /Б.Тожилсүрэн/-д даалгасугай.

Сэг зэм устгалын ажилд шаардлагатай төсвийг Засаг даргын Тамгын газрын эрсдэлийн сангийн зардлаас холбогдох журмын дагуу гаргахыг нягтлан бодогч /Д.Баярмаа/-д даалгасугай.

Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга /Г.Болд / –д үүрэг болгосугай,

ДАРГА



Д.БАЙГАЛМАА